



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/570

Булган сум

**Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.6, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/276 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг аймгийн хэмжээнд 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакцин, био бэлдмэлийг татан авч сумдад хуваарилан олгох, сумын мал эмнэлэг, малын эмч нарыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), дархлаажуулалтын ажлыг орон нутагт зохион байгуулан удирдлага, хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

0324010773

08
 Аймгийн Засаг даргын 2024 оны
 дүгээр сарын 05-ний өдрийн А/570
 Дугаар захирамжийн хавсралт

БРУЦЕЛЛЭЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТАД
 ХАМРУУЛАХ МАЛЫН ТОО, ШААРДАГДАХ ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	Хамрагдах малын тоо						Вакцины хуваарь				
		Тугал	Хурга	Ишиг	Бүгд	Rev-1			ШТАМ-19		Шингэлэгч /мл/	Шингэлэгч /ш/
						Тун	Вакцин /фл/	Тун	80 /тун/	70 /тун/		
1	Баян-Агт	7,702	28,358	9,470	45,530	37,800	108	7,680	96		53200	266
2	Баяннуур	493	893	899	2,285	4,200	12	720	9		5600	28
3	Бугат	717	11,063	6,099	17,879	17,150	49	960	12		19000	95
4	Булган	2,676	9,802	7,047	19,525	16,800	48	2,480	31		21800	109
5	Бүрэгхангай	2,362	41,847	19,001	63,210	60,550	173	2,320	29		65200	326
6	Гурванбулаг	2,481	38,145	17,615	58,241	55,650	159	2,480	31		60600	303
7	Дашинчилэн	4,187	19,810	9,138	33,135	28,700	82	4,160	52		37000	185
8	Могод	2,873	83,643	12,238	98,754	95,550	273	2,800	35		101200	506
9	Рашаант	6,688	57,844	28,631	93,163	86,450	247	6,640	83		99800	499
10	Орхон	2,208	29,078	14,738	46,024	43,750	125	2,160	27		48000	240
11	Сайхан	1,144	24,422	7,064	32,630	31,150	89	1,120	14		33400	167
12	Сэлэнгэ	6,483	12,283	6,105	24,871	18,200	52	6,480	81		31200	156
13	Тэшиг	5,052	16,604	10,181	31,837	26,600	76	5,040	63		36600	183
14	Хангал	2,726	9,497	6,114	18,337	15,400	44	2,720	34		21000	105
15	Хишиг-өндөр	4,507	57,928	22,927	85,362	80,850	231	4,480	56		89800	449
16	Хутаг-өндөр	1,691	26,760	12,756	41,207	39,200	112	1,750	21	1	42600	213
	Дун	53,990	467,977	190,023	711,990	658,000	1,880	53,990	674	1	766,000	3,830